

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/263-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга		
1.	Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
	2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
	2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5-6
	2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6-7
	2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7-8
	2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
	2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9-10
3.	Аудитын тайлан	10
	3.1 Ерөнхий зүйл	10
	3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10-12
	3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
	3.4 Материаллаг байдал	12
	3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12-13
	3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
	3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14-15
	3.8 Аудитын гол асуудал	15
	3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
	3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
	3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4.	Аудитын илрүүлэлт	15
	4.1 Зөвлөмж	16
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХЭДС	Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сан



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

2022.02.14 № СЭА-2022/263-НА-СТА-ТШЗ
Танган _____ -ны № _____

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	999,711,530.00	864,746,355.00
33	АВЛАГА	999,711,530.00	864,746,355.00
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	999,711,530.00	863,250,105.00
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	356,238,385.00	367,469,160.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	63,972,960.00	61,381,215.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	399,248,610.00	281,008,130.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	27,788,500.00	37,318,500.00
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	152,463,075.00	116,073,100.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,496,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	999,711,530.00	864,746,355.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	999,711,530.00	864,746,355.00
51	Засгийн газрын хувь оролцоо	999,711,530.00	864,746,355.00
51200	Хуримтлагдсан үр дүн	999,711,530.00	864,746,355.00
51210	Өмнөх үеийн үр дүн	999,711,530.00	999,711,530.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	(134,965,175.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	999,711,530.00	864,746,355.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	782,594,659.00	676,613,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,912,659.00	35,172,000.00
1200	Өмчийн орлого	161,912,659.00	35,172,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	161,912,659.00	35,172,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	161,912,659.00	35,172,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	620,682,000.00	641,441,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,611,000.00	641,441,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,611,000.00	15,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	251,000,000.00	626,126,000.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	352,071,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	352,071,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	924,684,682.00	811,578,175.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924,684,682.00	811,578,175.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,484,700.00	2,548,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,413,700.00	-
210401	Бичиг хэрэг	5,202,400.00	-

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	2,800,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,411,300.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,358,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	431714 108,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,000.00	1,190,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,000.00	-
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,190,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	914,199,982.00	809,029,275.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,462,181.35	35,172,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	161,912,659.00	35,172,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	39,549,522.35	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,611,000.00	13,566,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,611,000.00	13,566,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	510,090,023.00	520,851,098.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	510,090,023.00	520,851,098.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	184,036,777.65	239,440,077.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	184,036,777.65	239,440,077.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(142,090,023.00)	134,965,175.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(142,090,023.00)	(134,965,175.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,292,403,432.00	676,613,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	671,721,432.00	35,172,000.00
1200	Өмчийн орлого	671,721,432.00	35,172,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	671,721,432.00	35,172,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	509,808,773.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	161,912,659.00	35,172,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	620,682,000.00	641,441,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	268,611,000.00	641,441,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,611,000.00	15,315,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	251,000,000.00	626,126,000.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	352,071,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	352,071,000.00	-
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	451,461,425.00
145	Бусад орлого (олз)	-	451,461,425.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,292,403,432.00	1,128,074,425.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,292,403,432.00	1,128,074,425.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,071,000.00	2,548,900.00

**Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,358,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,250,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	108,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,000.00	1,190,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,071,000.00	1,190,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,291,332,432.00	1,125,525,525.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,462,181.35	36,668,250.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	161,912,659.00	36,668,250.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	39,549,522.35	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,611,000.00	13,566,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,000,000.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,611,000.00	13,566,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	509,808,773.00	520,851,098.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	509,808,773.00	520,851,098.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	561,450,477.65	554,440,077.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	561,450,477.65	554,440,077.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III-I-II)	-	(451,461,425.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	451,461,425.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	451,461,425.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)	-	451,461,425.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	999,711,530.00	-	999,711,530.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	999,711,530.00	-	999,711,530.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	(134,965,175.00)	-	(134,965,175.00)
16	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	864,746,355.00	-	864,746,355.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
00000	Төрийн сан	671,721,432.00	
00000	Төрийн сан	671,721,432.00	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	671,721,432.00	449,965,175.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	671,721,432.00	(1,496,250.00)
300011	Орлого төвлөрүүлэн шилжүүлэх	671,721,432.00	(1,496,250.00)
32	ЗГ-ын гадаадын төслийн зээл		451,461,425.00
321102	Үндсэн төлбөр (ЗГ-ын дотоод зээл)		451,461,425.00
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	352,071,000.00	
80110	Гадаад зээл, тусламжийн ТЕЗ-д шилжих ажил үйлчилгээ	1,071,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,071,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,071,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,071,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,071,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,071,000.00	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,071,000.00	
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	1,071,000.00	
300001	Харилцах болон хадгаламжийн өөрчлөлт	1,071,000.00	
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	350,000,000.00	
12	Татварын бус орлого	1,021,721,432.00	
120	Нийтлэг татварын бус орлого	671,721,432.00	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Үндсэн/	509,808,773.00	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	350,000,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	350,000,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	350,000,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	350,000,000.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	350,000,000.00	
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-		
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	645,069,200.00	627,874,900.00	17,194,300.00	97.3
80110	Гадаад зээл, тусламжийн ТЕЗ-д шилжих ажил үйлчилгээ	15,315,000.00	1,748,900.00	13,566,100.00	11.4
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,315,000.00	1,748,900.00	13,566,100.00	11.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,315,000.00	1,748,900.00	13,566,100.00	11.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,315,000.00	1,748,900.00	13,566,100.00	11.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	558,900.00	1,941,100.00	22.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	450,000.00	550,000.00	45.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	108,900.00	1,391,100.00	7.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,815,000.00	1,190,000.00	11,625,000.00	9.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,815,000.00	1,190,000.00	11,625,000.00	9.3
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,315,000.00	1,748,900.00	13,566,100.00	11.4
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(13,566,100.00)	13,566,100.00	
300008	Гадаад орон, олон улсын байгууллага дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл	-	(13,566,100.00)	13,566,100.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,315,000.00	15,315,000.00		- 100.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	15,315,000.00	15,315,000.00		- 100.0
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,548,200.00	4,000,000.00	548,200.00	87.9
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,548,200.00	4,000,000.00	548,200.00	87.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,548,200.00	800,000.00	3,748,200.00	17.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,548,200.00	800,000.00	3,748,200.00	17.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	4,548,200.00	800,000.00	3,748,200.00	17.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,548,200.00	800,000.00	3,748,200.00	17.6
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,200,000.00	(3,200,000.00)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,200,000.00	(3,200,000.00)	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,548,200.00	4,000,000.00	548,200.00	87.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,548,200.00	4,000,000.00	548,200.00	87.9
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	4,548,200.00	4,000,000.00	548,200.00	87.9
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	625,206,000.00	622,126,000.00	3,080,000.00	99.5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	625,206,000.00	622,126,000.00	3,080,000.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	625,206,000.00	554,440,077.00	70,765,923.00	88.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	625,206,000.00	554,440,077.00	70,765,923.00	88.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	625,206,000.00	554,440,077.00	70,765,923.00	88.7

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	625,206,000.00	554,440,077.00	70,765,923.00	88.7
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	67,685,923.00	(67,685,923.00)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	67,685,923.00	(67,685,923.00)	
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	625,206,000.00	622,126,000.00	3,080,000.00	99.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	625,206,000.00	622,126,000.00	3,080,000.00	99.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	625,206,000.00	622,126,000.00	3,080,000.00	99.5
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн тус сангаас олгосон санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн авлага болон ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.


Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд зааснаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах,
- Ажилд зуучлах,
- Хөдөлмөрт бэлтгэх,
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах,



- Ажил олгогчийг дэмжих,
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах,
- Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих,
- Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих,
- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх,
- Хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:


- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын шинэчлэгдсэн,
- Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, 2 дугаар хавсралтаар “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, 3 дугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, 4 дүгээр хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, 5 дугаар хавсралтаар “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” тус тус шинэчлэгдсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус сангийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.



3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 562,521.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,437.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 6,328.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 1.4-т “Сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сантай байна.” гэж заасны дагуу тус сангийн санхүүгийн байдлын тайланд бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг хөрөнгийн бусад хэлбэрүүд тусгагдаагүй байна.

Тус сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон санхүүгийн дэмжлэгийн авлагыг 134,965.2 мянган төгрөгөөр барагдуулснаар 2021 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт авлага өмнөх оноос 13.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	999,711.5	864,746.3	(134,965.2)
Урьдчилгаа			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	999,711.5	864,746.3	(134,965.2)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	999,711.5	864,746.3	(134,965.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	999,711.5	864,746.3	(134,965.2)

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 864,746.3 мянган төгрөг болж 134,965.2 мянган төгрөгөөр буурсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь өмнөх оноос 105,981.6 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар буурсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 126,740.7 мянган төгрөгөөр буурснаас голлон шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь өмнөх оноос 113,106.5 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар буурсан нь ковид-19 цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ / Иргэд олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, зөвлөгөө өгөх гэх мэт/ болон үйл ажиллагаа / бичиг хэрэг, хяналтын шалгалтын томилолт, шатахуун/-ны зардал буурснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,191,732.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,191,732.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 592,407.8 мянган төгрөгөөр бууруулж 599,324.2 мянган төгрөгөөр баталсан нь коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-н хүртэл сунгаснаар иргэд, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

ХХҮЕГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/337 дугаар тушаалаар батлагдсан төсөвт өөрчлөлт оруулж, 60,430.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтийг 629,754.2 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 30,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

Мөн ХХҮЕГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/127 дугаар тушаалаар Хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрт 15,315.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний 2, үйл ажиллагааны 1 зэрэг нийт 26 арга хэмжээг санхүүжүүлэхээр 629,754.2 мянган төгрөгийг ХЭДС-аас, 30,000.0 мянган төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос, 15,315.0 мянган төгрөгийг Дэлхийн банкны хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 626,126.0 мянган төгрөг, Дэлхийн банкны хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрөөс 15,315.0 мянган төгрөг зэрэг нийт 641,441.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 5 хөтөлбөрт 520,823.7 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний болон үйл ажиллагааны зардалд 34,416.4 мянган төгрөг, хөдөлмөрийн зах зээлийн туршилтын зардалд 1,748.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 84,452.0 мянган төгрөгийг төв санд буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант онд 318 иргэний санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн 451,461.4 мянган төгрөг, 5 аж ахуйн нэгжээс хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн 35,172.0 мянган төгрөг зэрэг нийт 486,633.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, улирал бүр төв ХЭДС-ийн 100900037010 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 556,989.0 мянган төгрөг буюу 86.8 хувьтай байгаа нь хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардал 70,885.9 мянган төгрөгөөр, Дэлхийн банкны хөдөлмөрийн зах зээлийн туршилтын хөтөлбөрийн зардал 13,566.1 мянган төгрөгөөр хэмнэгдэж, төв санд буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Тайлант онд Швейцарын хөгжлийн агентлаг, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн 26,326.0 мянган төгрөгийн санхүүжилтээр орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн загвар төв”-ийг нээж, ажил хайгч залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ хийх, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө гаргах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байна.

3.7.2 Азийн хөгжлийн банкны 82,681.6 мянган төгрөгийн санхүүжилтээр иж бүрэн засвар хийгдэж, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан “Ажил мэргэжлийн төв”-ийг нээж, иргэдэд ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн Нийтлэг үйлчилгээг олон нийтэд түргэн шуурхай хүргэх боломжийг нэмэгдүүлсэн байна.

3.7.3 Мөн ХЭДС-ийн онлайн heds.explorer.net программыг өргөжүүлэн сайжруулснаар сумын мэргэжилтнүүд тусгай кодоор программд нэвтэрч, цахимаар хяналт тавих нөхцөл бүрдсэн бөгөөд санхүүгийн дэмжлэг хуваарийн дагуу төлөгдөхгүй байх, хуваарь зөрчигдөх зөрчил багасах хандлагатай болсон байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд ХЭДС-ийн мэдээлбэл зохих 149 мэдээлэл байршуулахаас 148 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээлэл / *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) I-ийг* хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Малын хорогдлыг холбогдох нотлох баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасны үндсэн дээр данс бүртгэлээс хасаж, тайлагнаж байх” гэсэн албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитаар тус сангийн хөтөлбөрт хамрагдсан бичил аж ахуй эрхлэгч иргэд нь санхүүгийн дэмжлэгийг шалгарсан төсөл, гэрээний үндсэн дээр зориулалтын дагуу байгаа ашиглаж байгаатай холбоотой асуудлыг дараагийн аудитаар газар дээр үзэж, тулган баталгаажуулах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн авлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: 2021 оны жилийн эцсийн байдлаар тус сангийн 4 хөтөлбөрөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр 29 иргэнд олгосон нийт 53,193.9 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн байна. Энэ нь “Аж ахуй, бичил бизнес эрхлэгчид санхүүгийн дэмжлэгийн гэрээ”, “Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэгийн гэрээ”, “Аж ахуй, бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”, “Аж ахуй, бичил бизнес эрхлэгч ахмадад санхүүгийн дэмжлэг олгох гэрээ”-ний 3.10 дахь “Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын дагуу зарцуулж, хавсралтад тусгагдсан “Эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу санхүүгийн дэмжлэгийг эргэн төлнө.” гэсэн заалт болон “Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хуваарь”-ийг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дэмжлэгийг гэрээ болон “Эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу хугацаанд нь төлүүлж байх, эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн зээлийг холбогдох хуулийн дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлж, санг хохиролгүй болгох арга хэмжээ авах.

2. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Ерөө сумын ЗДТГ нь албан хаагчдад хууль эрх зүйн чиглэлээр ахмад мэргэжилтэн Х.Дөлхүүгээр зөвлөх үйлчилгээ авах төсөл ирүүлсэн боловч ой хээрийн түймэр, гал түймэр гарсан нөхцөлд хэрхэн ажиллах, галын машиныг ажиллуулах дадлага сургуулилалт хийсэн талаар тайлагнасан байна. Энэ нь хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх төслийг зориулалтын бус зарцуулсан мэт ойлголтыг төрүүлж байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, тайланг үнэн зөв гаргуулсны үндсэн дээр санхүүжилтийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХЭДС	2	53,193.9							2	53,193.9